

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 02 сарын 06-ны
өдрийн 6599 дугаарт бүртгэв.

2024 оны 01 сар 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох
зээлийн хүүгийн дээд хэмжээ”-г тогтоох тухай

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.2,
Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн
үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувиар тогтоосугай.
2. Энэ тогтоолоор баталсан зээлийн хүүгийн дээд хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдэд үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолоор баталсан зээлийн хүүгийн дээд хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Н.ХҮДЭРЧУЛУУН

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 02 сарын 06-ны
өдрийн 6595 дугаарт бүртгэв.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 сар 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан
даалтын гэрээний ерөнхий загвар”-ыг батлах тухай

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.1,
Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн
үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн
гэрээний ерөнхий загварыг нэгдүгээр, барьцааны гэрээний ерөнхий загварыг хоёрдугаар,
батлан даалтын гэрээний ерөнхий загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэ тогтоолоор баталсан зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий
загварыг мөнгөн зээлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөхийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа
эрхлэх этгээдүүдэд үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолоор баталсан гэрээний ерөнхий загваруудыг 2024 оны 3 дугаар сарын 01-
ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА *Н. Хүдэрчулуун* Н.ХҮДЭРЧУЛУУН



Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын
зөвлөлийн 2024 оны ... сарын ... ны өдрийн
002 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

20.. оны ... сарын ...-ний өдөр

№ ...

хот/аймаг

Энэхүү **ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас /хот, аймаг/ дахь
.....” ХХК (цаашид “Зээлдүүлэгч” гэх), нөгөө талаас /иргэн, хуулийн этгээд/-
ийн бүртгэлтэй хаягт оршин суух регистрийн
дугаартай ХХК, овогтой иргэний
бүртгэлийн дугаар:..... (цаашид “Зээлдэгч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын
Иргэний хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль, бусад холбогдох хууль, журмыг
үндэслэн харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгөөр байгуулав.

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.Гэрээний зорилго нь зээлдүүлэгч тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг хугацаатай, хүүтэй,
барьцаатай, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлдэгчид зээлдүүлэх, буцаан төлөхтэй холбогдсон
харилцааг зохицуулахад оршино.

1.2.Гэрээнд заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.2.1.Зээлийн хүү - зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцох зээлийн
хариу төлбөрийг;

1.2.2.Зээлийн эргэн төлөх хуваарь - зээлийн эргүүлэн төлөх хэмжээ, хүүгийн хэмжээ, хугацааг
заасан талуудын тохиролцоог;

1.2.3.Нэмэгдүүлсэн хүү - үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй.

1.2.4.Барьцаа - зээлдэгчээс зээлээ буцаан төлөх баталгаа болгож зээлдүүлэгчид
барьцаалуулж байгаа зээлдэгчийн болон батлан даагчийн, барьцаалуулагчийн хөрөнгө.

ХОЁР.ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

2.1.Зээлийн хэмжээ: /тоогоор//үсгээр/

2.2.Зээлийн үндсэн хүү: сарын %

2.2.1.нэмэгдүүлсэн хүү тооцох эсэх: тийм, үгүй /доогуур зурах/

2.2.2.нэмэгдүүлсэн хүү тооцох бол хүүгийн хэмжээ %

2.3.Зээлийн төрөл:

2.4.Зээлийн эргэн төлөлтийн хуваарь

2.5.Барьцааны гэрээний огноо, дугаар:

2.6.Батлан даалтын гэрээний огноо, дугаар:

2.7.Зээлийн хүүг тооцохдоо Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Мөнгөн зээлийн үйл
ажиллагааны бодлогын зөвлөлөөс баталсан хүү тооцох аргачлалыг ашиглана.

2.8.Зээл олгох хэлбэр: бэлнээр, дансаар /доогуур зурах/

2.8.1.Зээлдэгчийн мөнгө хүлээн авах дансны дугаар:

2.8.2.Банкны нэр:

2.8.3.Данс эзэмшигчийн нэр:

2.9.Зээлийг эргэн төлөх хэлбэр:

2.9.1.Зээлдүүлэгчийн мөнгө хүлээн авах дансны дугаар:

2.9.2.Банкны нэр:

2.9.3.Данс эзэмшигчийн нэр:

2.10.Зээлийн хүүг зээлийг ашигласан хугацаагаар тооцно.

2.11.Зээлийн ашигласан хугацаа нь зээлдүүлэгчээс зээлдэгчид гэрээнд тохиролцсон хэлбэрээр зээл олгосноор эхэлж, зээлдэгч зээлдүүлэгчид буцаан төлснөөр дуусгавар болно.

ГУРАВ.ЗЭЭЛДҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Зээлдүүлэгч нь гэрээ байгуулахдаа зээлийн нөхцөл бүрийг зээлдэгчид тайлбарлаж өгөх үүрэгтэй.

3.2.Зээлдүүлэгч нь гэрээг бичгээр хийж, гэрээнд зээлийн хүүгийн хэмжээ, зээлийн нөхцөлийг тодорхой тусгах үүрэгтэй.

3.3.Зээлдүүлэгч зээлтэй холбоотой аливаа төлбөр тооцоо, бүртгэлийг үнэн зөв гүйцэтгэж баталгаажуулах үүрэгтэй.

3.4.Зээлдэгч зээлээ төлсөн, эсхүл хууль, гэрээнд заасны дагуу гэрээний үүрэг дуусгавар болсон тохиолдолд зээлдүүлэгч зээлдэгчийн зээлийн дансыг хааж, зээлийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх үүрэгтэй.

3.5.Зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож зээлийг буцаан төлөх чадваргүй болох нөхцөл байдал бий болохоор, эсхүл болсон бол зээлдүүлэгч зээл олгохоос татгалзах, эсхүл олгосон зээлийг буцаан төлөхийг шаардах эрхтэй.

3.6.Зээлдэгч үндсэн зээл, зээлийн хүүгээ гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдүүлэгч хууль болон гэрээнд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй.

3.7.Зээлдүүлэгч зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээ байгуулахад аливаа шимтгэл, хураамж, эсхүл нэмэлт төлбөр авахгүй.

3.8.Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс баталсан зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрүүлэн хүүг тооцохгүй.

3.9..... /хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцсон бусад/

ДӨРӨВ.ЗЭЭЛДЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Зээлдэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсноор гэрээнд заасан хэмжээний зээлийг авч ашиглах эрхтэй.

4.2.Зээлдэгч зээлийн дансны гүйлгээний хуулга, зээлтэй холбоотой баримтыг авах эрхтэй.

4.3.Зээлдэгч нь гэрээ байгуулах, барьцаа хөрөнгөд өөрчлөлт оруулах, барьцаа хөрөнгөө хүлээж авах эрхтэй.

4.4.Зээлдэгч барьцаа хөрөнгийн үнэлгээний дүнгээс хамаарч зээлийн мөнгөн дүнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах эрхтэй.

4.5.Зээлдэгч зээл авахдаа зээлдүүлэгчид зээлийн хүүг урьдчилан төлөхгүй.

4.6.Зээлдэгч гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө хэдийд ч гэрээний үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гүйцэтгэх эрхтэй.

4.7.Зээлдэгч зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өдрөөс өмнө төлөлт хийх тохиолдолд ашигласан хугацаагаар зээлийн хүүг төлнө.

4.8.Зээлийг бүхэлд нь болон хэсэгчлэн бусдад ашиглуулах, дамжуулан зээлдүүлэх, шилжүүлсэн зээлээс үл хамааран гэрээний үүргээ зээлдэгч өөрөө хариуцна.

4.9.Зээлдэгч нь зээлийн үндсэн төлбөр, хүүг гэрээнд заасан хугацаанд буцаан төлөх үүрэгтэй ба энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээнд заасан хувиар нэмэгдүүлсэн хүү төлнө.

4.10...../хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцсон бусад/

ТАВ.БУСАД

5.1.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөлд түүнийг гагцхүү бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5.2.Талуудын гэрээнд заасан хаяг байршил, холбоо барих мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай нөгөө талдаа 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба ийнхүү мэдэгдээгүйн улмаас гэрээнд заасан хаягаар хүргүүлсэн аливаа мэдэгдэл, санал, хүсэлт, гомдол, нэхэмжлэл зэргийг хүлээн авсанд тооцож, эрх зүйн үр дагавар үүснэ.

5.3.Зээлдүүлэгч, зээлдэгч тус бүр гэрээний эх хувийг хадгалах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хувь үйлдэж болно.

5.4.Гэрээний бичвэр нь ойлгомжтой, үсгийн фонтын хэмжээ 9-с багагүй, уншигдахуйц тод хэвлэгдсэн байна.

5.5.Гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд уг маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу /талууд гэрээнд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлэхээр зааснаас бусад тохиолдолд/ Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗЭЭЛДҮҮЛЭГЧ:

..... (.....)

овог, нэр *гарын үсэг*

Хаяг:

Утас:

(Тамга)

ЗЭЭЛДЭГЧ:

..... (.....)

овог, нэр *гарын үсэг*

Хаяг:

Утас:

(Тамга)

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн 2024 оны ... сарын 18-ны өдрийн 02 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт



БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

20.. оны ... сарын ...-ний өдөр

№ ...

хот/аймаг

Энэхүү **БАРЬЦААНЫ ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас..... /хот, аймаг/ дахь” ХХК (цаашид “Барьцаалагч” гэх), нөгөө талаас /иргэн, хуулийн этгээд/-ийн бүртгэлтэй хаягт оршин суух регистрийн дугаартай ХХК, овогтой иргэний бүртгэлийн дугаар:..... (цаашид “Барьцаалуулагч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, бусад холбогдох хууль, журмыг үндэслэн харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгөөр байгуулав.

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэ гэрээгээр 20 ... оны ... сарын ... -ны өдөр талуудын байгуулсан № ... зээлийн гэрээ (цаашид “зээлийн гэрээ” гэх)-ний үүргийн биелэлтийг хангах зорилгоор барьцаалуулагчаас зээлийн барьцаанд барьцаалуулж буй барьцааны зүйл (Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувьд зөвхөн хөдлөх хөрөнгө), үүнээс үүдэн гарч буй эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2. Барьцааны гэрээний хугацаа зээлийн гэрээг байгуулсан цагалбартай адил байна.
- 1.3. Барьцаа хөрөнгийг барьцаалуулагчтай харилцан тохиролцож, бодитой үнэлэх ба барьцаагаар хангах шаардлагын хэмжээ /төгрөг/ байна.
- 1.4. Барьцаалуулагч нь зээлийн гэрээнд заасан зээлдэгч, эсхүл гуравдагч этгээд байж болно.
- 1.5. Барьцааны мэдэгдэл хүргүүлэх хэлбэр:

ХОЁР.БАРЬЦААНЫ ЗҮЙЛ

2.1. Барьцаалуулагч нь барьцаалагчтай харилцан тохиролцсоноор зээлийн гэрээний барьцаа болгож доорх хөрөнгө, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгнө. Үүнд:

№	Барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл	Тайлбар
1.	Барьцаа хөрөнгийн нэр төрөл, зориулалт	
2.	Барьцаа хөрөнгийн өмчлөгчийн мэдээлэл (иргэн бол нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг)	
3.	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	
4.	Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, баримт бичгийн дугаар	
5.	Барьцаа хөрөнгийн тоо ширхэг	
6.	Барьцаа хөрөнгийн шинж тэмдэг	

7.	Барьцаалсан бүртгэлийн дугаар	
8.	Барьцааны зүйлийг эзэмшилдээ байлгах тал	
9.	Барьцааны зүйлийн хаяг, байршил	
10.	Үүргийг хангах хугацаа	
11.	Бусад	

ГУРАВ.БАРЬЦААЛУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Барьцаалуулагч нь зээлийн гэрээнд заасан зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлээр зээлийн үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр, гэрээний үүргийн биелэлт хангахтай холбогдон гарсан зардлыг тооцож төлнө.

3.2.Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг гэрээний хугацаанд барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр худалдах, бэлэглэх, барьцаалах, батлан даалт гаргах зэргээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

3.3.Барьцаалуулагч барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгох эрхтэй.

3.4.Барьцаалуулагч нас барсан, гэнэтийн тохиолдлоор эрх зүйн чадамжгүй болсон нөхцөлд барьцааны зүйлтэй холбогдох эрх, үүрэг нь Монгол Улсын Иргэний хуулийн дагуу түүний хууль ёсны өв залгамжлагчид шилжинэ.

3.5..... /хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцсон бусад/

ДӨРӨВ.БАРЬЦААЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Барьцаалагч барьцааны зүйлийг өөрийн эзэмшилд байлгах тохиолдолд барьцааны зүйл, эзэмшилтэй холбоотой шилжүүлсэн баримт бичгийн бүрдэл, холбогдох материалын бүрэн бүтэн байдлыг харууцна.

4.2.Барьцаалагч Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан цахим мэдээллийн санд бүртгэгдсэн эд зүйлсийг барьцаанд авахаас таггалзах үүрэгтэй.

4.3.Барьцаалагч Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан сэжиг бүхий эд зүйлсийн талаар цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй.

4.4.Барьцаалагч барьцааны зүйлийг өөрийн эзэмшилд байлгах хугацаанд барьцааны зүйл устаж, үрэгдсэн тохиолдолд хөрөнгийн үнийг зохих ёсоор барьцаалуулагчид нөхөн төлж хохиролгүй болгох үүрэгтэй.

4.5.Барьцаалагч барьцааны зүйлийг өөрийн эзэмшилд байлгах хугацаанд барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд эзэмших эрхийг шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

4.6.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасан хугацаанд барьцааны шаардлагыг хангаагүй бол барьцаалагч барьцааны зүйлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж, уг орлогоос барьцааны шаардлагыг хангаж, үлдсэн хэсгийг барьцаалуулагчид олгох үүрэгтэй.

4.7.Барьцаалагч нь барьцаалуулагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн нөхцөлд барьцааны зүйлийг барьцаалуулагчид, эсхүл барьцаалуулагчийн зөвшөөрөлтэйгөөр зээлдэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчид шилжүүлэн өгөх үүрэгтэй.

4.8.Барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээнд барьцааны зүйлийн үр шимийг олж авна.

4.9.Барьцаалуулагч өөрийнхөө эзэмшилд байгаа барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байна гэж үзвэл барьцаалагч барьцааны зүйлийг өөрийн эзэмшилд шилжүүлэхийг шаардах эрхтэй.

4.10..... /хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцсон бусад/

ТАВ.БУСАД

5.1.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөлд түүнийг гагцхүү бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5.2.Талуудын гэрээнд заасан хаяг байршил, холбоо барих мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай нөгөө талдаа 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба ийнхүү мэдэгдээгүйн улмаас гэрээнд заасан хаягаар хүргүүлсэн аливаа мэдэгдэл, санал, хүсэлт, гомдол, нэхэмжлэл зэргийг хүлээн авсанд тооцож, эрх зүйн үр дагавар үүснэ.

5.3.Барьцаалагч, барьцаалуулагч тус бүр гэрээний эх хувийг хадгалах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хувь үйлдэж болно.

5.4.Гэрээний бичвэр нь ойлгомжтой, үсгийн фонтын хэмжээ 9-с багагүй, уншигдахуйц тод хэвлэгдсэн байна.

5.5.Гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд уг маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу /талууд гэрээнд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлэхээр зааснаас бусад тохиолдолд/ Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

БАРЬЦААЛАГЧ:

БАРЬЦААЛУУЛАГЧ:

..... (.....)

..... (.....)

овог, нэр *гарын үсэг*

овог, нэр *гарын үсэг*

Хаяг:

Хаяг:

Утас:

Утас:

(Тамга)

(Тамга)

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын
зөвлөлийн 2024 оны ... сарын ... ны өдрийн
... тоот тогтоолын гуравдугаар хавсралт



БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ

20.. оны ... сарын ...-ний өдөр

№

..... хот/аймаг

Энэхүү **БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас..... /хот, аймаг/ дахь” ХХК (цаашид “Үүрэг гүйцэтгүүлэгч” гэх), нөгөө талаас /иргэн, хуулийн этгээд/-ийн бүртгэлтэй хаягт оршин суух регистрийн дугаартай ХХК, овогтой иргэний бүртгэлийн дугаар:..... (цаашид “Батлан даагч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, бусад холбогдох хууль, журмыг үндэслэн харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгөөр байгуулав.

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэ гэрээгээр батлан даагч нь 20 ... оны ... сарын ... -ны өдөр талуудын байгуулсан № ... зээлийн гэрээ (цаашид “зээлийн гэрээ” гэх)-ний үүргийн биелэлтийг хангах зорилгоор зээлийн гэрээнд заасан зээлдэгч (цаашид “үүрэг гүйцэтгэгч” гэх)-ээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж чадна гэдгийг баталж, хэрэв гэрээний үүргээ зөрчсөн, үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд гэрээгээр тохиролцсон хэмжээгээр үүрэг хүлээх гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөв.

1.2. Батлан даалтын дээд хэмжээ ... /тоогоор/ /үсгээр/ төгрөгийн үнийн дүн бүхий байна.

1.3. Үүрэг гүйцэтгэгч нас барсан, гэнэтийн тохиолдлоор эрх зүйн чадамжгүй болсон нөхцөлд барьцааны зүйлтэй холбогдох эрх, үүрэг нь Монгол Улсын Иргэний хуулийн дагуу түүний хууль ёсны өв залгамжлагчид шилжиж, өвлөгч өвлөсөн хөрөнгийн хэмжээгээр үүргийн гүйцэтгэлийг хариуцах бөгөөд батлан даагч нөхөн төлөгдөөгүй хэсгээр хариуцлага хүлээнэ.

1.4. Батлан даагчийн хүлээх үүрэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгт хамаарна.

1.5. Үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус болсноор түүний гүйцэтгэлийг хангах тухай батлан даалтын гэрээ хүчин төгөлдөр бус болно.

1.6. Гэрээг байгуулсны дараа үүрэг гүйцэтгэгчийн хийсэн хэлцлээс бий болох үр дагаврыг батлан даагч хариуцахгүй.

ХОЁР.БАТЛАН ДААГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Гэрээгээр батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс нөхөх хариуцлага хүлээнэ.

2.2. Батлан даагч гэрээнд заасан хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

2.3. Үүрэг гүйцэтгүүлэгчээс батлан даагчид шаардлага гаргавал үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох бүх татгалзлыг батлан даагч гаргах эрхтэй.

2.4. Үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох татгалзлаасаа үүрэг гүйцэтгэгч татгалзсан ч батлан даагч татгалзал гаргах эрхээ алдахгүй.

2.5. Батлан даагч нэг талын санаачилгаар батлан даалтын гэрээг цуцалсан бол ийнхүү цуцлахаас өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.

2.6. Батлан даагч үүрэг гүйцэтгэсэн бол энэхүү үүргийн талаархи үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх эрх түүнд шилжих бөгөөд ийнхүү эрх шилжих нь батлан даалттай холбогдолгүй үүрэг гүйцэтгүүлэгчийн бусад эрхийг хөндөхгүй.

2.7. Үүрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх батлан даагчид шилжих үед үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах байсан бүх татгалзлаа батлан даагчид гаргах эрхтэй.

2.8. /хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцсон бусад/

ГУРАВ.ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаандаа биелүүлээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч энэ тухай батлан даагчид мэдэгдэнэ.

3.2. Батлан даагч шаардсан бол үүрэг гүйцэтгүүлэгч үндсэн гэрээгээр үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүргийн талаар түүнд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.

3.3. Үүрэг гүйцэтгүүлэгч энэ гэрээний 3.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол тэрээр үүрэг гүйцэтгээгүйн улмаас үүсэх хохирлын хэмжээгээр батлан даагчийн эсрэг шаардлага гаргах эрхээ алдана.

3.4. Үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг батлан даагч үүрэг гүйцэтгэгчтэй хамтран хариуцахаар гэрээнд заасан бол үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт тодорхой байвал үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэхийг батлан даагчаас шаардах эрхтэй.

3.5. /хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцсон бусад/

ДӨРӨВ.БУСАД

4.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөлд түүнийг гагцхүү бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.2. Талуудын гэрээнд заасан хаяг байршил, холбоо барих мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай нөгөө талдаа 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба ийнхүү мэдэгдээгүйн улмаас гэрээнд заасан хаягаар хүргүүлсэн аливаа мэдэгдэл, санал, хүсэлт, гомдол, нэхэмжлэл зэргийг хүлээн авсанд тооцож, эрх зүйн үр дагавар үүснэ.

4.3. Үүрэг гүйцэтгүүлэгч, батлан даагч тус бүр гэрээний эх хувийг хадгалах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хувь үйлдэж болно.

4.4. Гэрээний бичвэр нь ойлгомжтой, үсгийн фонтын хэмжээ 9-с багагүй, уншигдахуйц тод хэвлэгдсэн байна.

4.5. Гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд уг маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу /талууд гэрээнд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлэхээр зааснаас бусад тохиолдолд/ Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ:

..... (.....)

овог, нэр гарын үсэг

Хаяг:

Утас:

(Тамга)

БАТЛАН ДААГЧ:

..... (.....)

овог, нэр гарын үсэг

Хаяг:

Утас:

(Тамга)

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 02 сарын 06-ны
659/6 дугаарт бүртгэв.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 сар 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох
зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлал”-ыг батлах тухай

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.3,
Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн
үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хэмжээг
бодох, тооцох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох
зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлал”-ыг мөнгөн зээлийн үйл ажиллагаанд
дагаж мөрдөхийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүдэд үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолоор баталсан аргачлалыг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн
дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Н.ХҮДЭРЧУЛУУН



Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын
зөвлөлийн 2024 оны 03 сарын 18 ны өдрийн
03 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭЭС ОЛГОХ ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН
ХЭМЖЭЭГ БОДОХ, ТООЦОХ АРГАЧЛАЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү аргачлалыг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хувь хэмжээг бодох, тооцох үйл ажиллагаанд мөрдөнө.

Хоёр. Зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү тооцох

2.1 Зээлийн хүү

Зээлийн хүүг бодохдоо:

Хүү = Зээлийн дүн * Хүүгийн хувь (жилээр) * Хугацаа/365

$$I = P * R * T / 365$$

I – Хүү

P – Зээлийн дүн

R – Хүүгийн хувь (жилээр)

T – Хугацаа (хуанлийн хоногоор)

Жишээ 1 : 1,000,000₮-ийг сарын 5%-ийн хүүтэйгээр зээлдүүлсэн ба зээлийг 14 хоног ашиглан буцаан төлсөн тохиолдолд ашигласан хугацаагаар зээлийн хүүг дараах байдлаар тооцно:

$$P = 1,000,000₮ \quad R = 0.05 = \left(\frac{5}{100}\right) \quad T = 14$$

$$I = 1,000,000 * (0.05 * 12) * \frac{14}{365} = 23,014₮$$

2.2 Нэмэгдүүлсэн хүү

Нэмэгдүүлсэн хүүг бодохдоо:

Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ = Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүн * Хүүгийн хувь (жилээр) * Нэмэгдүүлсэн хүүгийн хувь * Хугацаа хэтэрсэн хоног

$$I_t = P_{od} * R * R_t * \frac{T_{od}}{365}$$

I_t - Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ

P_{od} - Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүн

R - Хүүгийн хувь хэмжээ (жилээр)

R_t - Нэмэгдүүлсэн хүүгийн хувь (20 хувиас хэтрүүлэхгүй)

T_{od} - Хугацаа хэтэрсэн хоног

Жишээ: 1,000,000₮-ийг сарын 5%-ийн хүүтэй зээлдүүлсэн ба гэрээнд заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоногт үндсэн хүүгийн 20 хувьтай тэнцэхүйц хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр тохиролцсон. Зээлдэгч зээлийн гэрээний дагуу төлөх байсан 500,000₮-ийг заасан хугацаандаа төлөөгүй бөгөөд төлбөрийг гэрээний хугацаа дууссанаас хойш 7 хоногийн дараа хийсэн бол мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн зүгээс тооцож авах нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг дараах байдлаар бодно.

$$P_{od} = 500,000\text{₮} \quad R = 0.05 = \left(\frac{5}{100}\right) \quad T_{od} = 7$$

$$I = 500,000\text{₮} * \left((0.05 * 12) * 0.02 \right) * \left(\frac{7}{365} \right) = 115.07\text{₮}$$


2.3 Хэсэгчлэн төлөх нөхцөл бүхий зээлийн төлбөр

Зээлдэгч хэсэгчлэн төлөх нөхцөл бүхий зээлийг авахдаа (тухайлбал, автомашин барьцаалсан зээл гэх мэт) өөрийн төлбөрийн чадвар, орлогын мөнгөн урсгал хүрэлцээтэй нөхцөлд сар бүрийн нийт төлбөр тогтмол эсвэл сар бүрийн үндсэн төлбөр тогтмол гэсэн хувилбараас сонголт хийн бодох боломжтой.


Сарын нийт төлбөр тогтмол тохиолдолд зээл төлөх хугацааны эхэн үед зээлийн үндсэн төлбөр бага, хүүний төлбөр өндөр байдаг бол сүүл үед үндсэн төлбөр өндөр, хүүний төлбөр бага болдог.

Үндсэн төлбөр тогтмол тохиолдолд нийт зээлийн дүнг хэсэгчлэн төлөх давтамжид тэнцүү хувааж, харгалзах зээлийн үлдэгдлээс бодсон хүүний нийлбэрээр сарын төлөх төлбөрийг тодорхойлно.

Сарын нийт төлбөр тогтмол



Үндсэн төлбөр тогтмол



Сарын нийт төлбөр (үндсэн дүн + хүү) тогтмол байх зээлийн төлбөрийн хэмжээг тогтооход дараах томъёог ашиглана.

Илгэлцүүр ₁	=	$\frac{1}{\text{Зарласан хүүгийн хувь} * \text{Хугацаа}_1 / 365 + 1}$
Итгэлцүүр ₂	=	$\frac{\text{Илгэлцүүр}_1}{(\text{Зарласан хүүгийн хувь} * \text{Хугацаа}_2 / 365 + 1)}$
Итгэлцүүр ₃	=	$\frac{\text{Итгэлцүүр}_2}{(\text{Зарласан хүүгийн хувь} * \text{Хугацаа}_3 / 365 + 1)}$
гэх мэтээр зээл төлөх сарын тоотой тэнцүү тооны итгэлцүүрүүдийг олно. Энд хугацаа нь хуанлийн хоногоор 1 сар байна.		
Коэффициент	=	Итгэлцүүрүүдийн нийлбэр
Тэнцүү төлбөр =		$\frac{\text{Зээлийн дүн}}{\text{Коэффициент}}$

Жишээ: 2013 оны 12 сарын 4-ний өдөр авсан 20 жилийн хугацаатай 10,000,000₮-ийн барьцаат зээлийн жилийн хүү 8 хувь бол сар бүрийн төлбөр нь:

$$\text{Итгэлцүүр}_1 = \frac{1}{1 + 27 * \frac{0.08}{365}} = 0.99412\text{₮}$$

$$\text{Итгэлцүүр}_2 = \frac{\text{Итгэлцүүр}_2}{1 + 31 * \frac{0.08}{365}} = 0.98741$$

.....

$$\text{Коэффициент} = 119.62$$

$$\text{Сарын төлбөр} = \frac{10,000,000}{119.62} = 83.598\text{₮}$$

Сар бүрийн үндсэн төлбөр тогтмол хэсэгчлэн төлөх зээлийн төлбөрийг дараах томъёогоор бодно:

<p>Үндсэн төлбөр = Зээлийн нийт дүн/Эргэн төлөлт хийх огноо</p> <p>Хүүний төлбөр = Зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл * Хүүгийн хувь * Ашигласан хуанлийн хоног/365</p> <p>Тухайн хугацааны төлбөр = Үндсэн төлбөр + Хүүний төлбөр</p>
--

Жишээ: Сарын 5 хувийн хүүтэй 1 жилийн хугацаатай 1,000,000₮-ийн автомашины зээлийг сар бүр үндсэн төлбөр тэнцүү төлөх нөхцөлөөр 2022 оны 7-р сарын 01-ний өдөр авчээ. Тэгвэл:

Эргэн төлөлт хийх тоо = 1 жил * 12 сар = 12 удаа

Үндсэн төлбөр = 1,000,000₮ / 12 = 83,333₮

Хүүний төлбөр #1 = 1,000,000₮ * 0.05 * 31/365 = 4,247₮

Хүүний төлбөр #2 = 916,667₮ * 0.05 * 28/365 = 3,516₮ гэх мэт

Хүүний төлбөр #12 = 83,333₮ * 0.05 * 31/365 = 354₮ байна.

Эхний сарын төлбөр = 83,333₮ + 4,247₮ = 87,580₮

2 дахь сарын төлбөр = 83,333₮ + 3,516₮ = 86,849₮ гэх мэт сар бүрээр буурч...

12 дахь сарын төлбөр = 83,333₮ + 354₮ = 83,687₮ болно.

№	Зээлийн эхний үлдэгдэл	Сарын үндсэн төлбөр	Хүүний төлбөр	Сарын нийт төлбөр	Зээлийн эцсийн үлдэгдэл
1	1000000	83333	4247	87580	916667
2	916667	83333	3516	86849	833333
3	833333	83333	3539	86872	750000
4	750000	83333	3082	86416	666667
5	666667	83333	2831	86164	583333
6	583333	83333	2397	85731	500000
7	500000	83333	2123	85457	416667
8	416667	83333	1712	85046	333333
9	333333	83333	1370	84703	250000
10	250000	83333	1062	84395	166667
11	166667	83333	685	84018	83333
12	83333	83333	354	83687	0

---oOo---